



НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2022 болон 2023 оны 12 сарын 31-ний өдөр дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

(Канад доллараар)

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан
(Канад доллараар)

	Тодруулга	2023.12.31	2022.12.31
Хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		\$ 4,349,599	\$ 7,421,600
Дансны авлага		6,722	76,582
Урьдчилж төлсөн авлага		1,455,652	1,361,730
Эргэлтийн хөрөнгийн дүн		5,811,973	8,859,912
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	5	51,248,731	-
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	6	1,961,506	43,054,156
Үндсэн хөрөнгө	7	21,155	545,704
Хөрөнгө ашиглах эрх		19,581	73,594
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		53,250,973	43,673,454
Нийт хөрөнгийн дүн		\$ 59,062,946	\$ 52,533,366
Өр төлбөр ба эздийн өмч			
Арилжаа болон бусад өглөг		\$ 163,212	\$ 826,409
Түрээсийн өглөг		22,939	59,662
Богино хугацаат өр төлбөр		186,151	886,071
Түрээсийн өглөг		-	22,940
Урт хугацаат өр төлбөр		-	22,940
Нийт өр төлбөрийн дүн		186,151	909,011
Эздийн өмч			
Хувьцаат капитал	10	\$ 158,086,286	\$ 157,880,069
Нэмж төлөгдсөн капитал	10	30,147,989	28,727,197
Хуримтлагдсан ба бусад алдагдал		(849,598)	(5,952,986)
Алдагдал		(128,507,882)	(129,029,925)
Эздийн өмчийн дүн		58,876,795	51,624,355
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн		\$ 59,062,946	\$ 52,533,366

Гэрээг хүлээсэн үүрэг (Тодруулга 8)

Тайлант хугацаанд өрнөсөн үйл явдлууд (Тодруулга 5 & 15)

Дагалдах тодруулгууд нь хураангуй, нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

Төлөөлөн Удирдах Зөвлөх ("ТУЗ")-ийг төлөөлж баталсан:

Гарын үсэг зурсан "Петер К. Акерли"

ТУЗ-ийн гишүүн

Гарын үсэг зурсан "Жон П. Бюрн"

ТУЗ-ийн гишүүн

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн (Ашиг) Алдагдлын Дэлгэрэнгүй Тайлан
(Канад доллараар)

	Тодруулга	Дуусгавар болсон өдөр 12 сарын 31	
		2023	2022
Үйл ажиллагааны зардал			
Хайгуул, үнэлгээний зардал	11	\$ 847,010	\$ 3,798,676
Ерөнхий ба удирдлагын зардал	12	3,137,736	2,218,984
Үйл ажиллагаанаас учирсан алдагдал		3,984,746	6,017,660
Хараат компанийн хөрөнгө оруулалтын алдагдал	5	2,278,370	
Санхүүгийн орлого		(269,609)	(58,383)
Хүүгийн зардал		2,417	11,044
Гадаад валютын ханшийн зөрүүнээс гарсан гарз		26,897	15,916
Охин компанийн хяналт хуваагдсанаас үүссэн ашиг		(6,544,863)	
Цэвэр алдагдал		\$ (522,042)	\$ 5,986,237
Бусад дэлгэрэнгүй алдагдал (гарз):			
Охин компанийн хөрвүүлгээс үүдсэн гадаад валютын ханшийн зөрүү		7,508	2,926,628
Охин компанийн хяналт хуваагдхад үүдсэн гадаад валютын ханшийн зөрүү		(5,110,896)	
Бусад дэлгэрэнгүй алдагдал (гарз)		(5,103,388)	2,926,628
Нийт дэлгэрэнгүй алдагдал		\$ (5,625,430)	\$ 8,912,865
Нэгж хувьцаанд алдагдах суурь алдагдал		\$ (0.00)	\$ 0.02

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Өмчийн өөрчлөлтийн тайлан
(Канад доллараар)

	Тодруулга	Хувьцааны тоо ширхэг	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан бусад дэлгэрэнгүй алдагдал	Алдагдал	Нийт эздийн өмч
2023.01.01-ний үлдэгдэл		344,300,376	\$ 157,880,069	\$ 28,727,197	\$ (5,952,986)	\$ (129,029,925)	\$ 51,624,355
Тайлант үеийн нийт алдагдал							
Цэвэр алдагдал		-	-	-	-	522,043	522,043
Бусад дэлгэрэнгүй алдагдал		-	-	-	5,103,388	-	5,103,388
Хэрэгжүүлсэн опцион	10	250,000	90,350	(29,850)	-	-	60,500
ИОХЭ-ийн төлөвлөгөөний дагуу гаргасан энгийн хувьцаа	10	337,800	115,867	(115,867)	-	-	-
Хувьцаанд суурилсан урамшуулал	10	-	-	1,566,509	-	-	1,566,509
Эзэмшигчидтэй хийсэн нийт хэлцэл гүйлгээ		587,800	206,217	1,420,792	-	-	1,627,009
2023.12.31-ний үлдэгдэл		344,888,176	\$ 158,086,286	\$ 30,147,989	\$ (849,598)	\$ (128,507,882)	\$ 58,876,795
2022.01.01-ний үлдэгдэл		294,379,845	\$ 145,153,510	\$ 26,648,556	\$ (3,026,358)	\$ (123,043,688)	\$ 45,732,020
Тайлант хугацааны нийт алдагдал							
Цэвэр алдагдал		-	-	-	-	(5,986,237)	(5,986,237)
Бусад дэлгэрэнгүй алдагдал		-	-	-	(2,926,628)	-	(2,926,628)
Хаалттай хүрээнд гаргасан хувьцааны цэвэр зардал	10	49,860,531	12,703,159	1,079,795	-	-	13,782,954
Хэрэгжсэн опцион	10	60,000	23,400	(6,300)	-	-	17,100
Хувьцаанд суурилсан урамшуулал	10	-	-	1,005,146	-	-	1,005,146
Эзэмшигчидтэй хийсэн нийт хэлцэл гүйлгээ		49,920,531	12,726,559	2,078,641	-	-	14,805,200
2022.12.31-ний үлдэгдэл		344,300,376	\$ 157,880,069	\$ 28,727,197	\$ (5,952,986)	\$ (129,029,925)	\$ 51,624,355

Дагалдах тодруулгауд нь хураангуй, нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй, нэгтгэсэн завсрын мөнгөн гүйлгээний тайлан
(Канад доллараар)

Тодруулга	Дуусгавар болсон өдөр 12 сарын 31	
	2023	2022
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Цэвэр алдагдал	\$ 522,043	\$ (5,986,237)
Мөнгөн бус гүйлгээнүүд		
Элэгдэл, хорогдол	36,959	136,580
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	10 1,566,509	1,005,146
Санхүүгийн орлого	(269,609)	(58,383)
Мөнгөн бус гадаад валют	26,897	15,916
Хараат компанийн хөрөнгө оруулалтын алдагдал	5 2,278,370	-
Охин компанийн хяналт хуваагдсанаас үүссэн ашиг, алдагдал	5 (6,544,863)	-
Мөнгөн бус эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт	337,159	(250,385)
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(2,046,535)	(5,137,363)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Энгийн хувьцаагаар татан төвлөрүүлсэн цэвэр дүн	10 -	13,782,954
Опцион хэрэгжүүлсэн төлбөр	10 60,500	17,100
Түрээсийн төлбөрийн эргэн төлөлт	(32,621)	(63,041)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	27,879	13,737,013
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Хайгуул, хөрөнгийн үнэлгээний зардал	6 (1,043,280)	(7,971,955)
Үндсэн хөрөнгийн зардал	7 (3,085)	(296,747)
Хүүгийн орлого	269,609	58,383
Охин компанийг нэгтгэлээс гаргаснаас үүдэх мөнгөн алдагдал	(254,049)	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(1,030,805)	(8,210,319)
Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	(22,540)	(30,782)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн өсөлт	(3,072,001)	358,549
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, хугацааны эхэнд	7,421,600	7,063,051
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, хугацааны сүүлд	\$ 4,349,599	\$ 7,421,600

Дагалдах тодруулгууд нь хураангуй, нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Санхүүгийн тайлангийн тодруулга
(Канад доллараар)

2022 болон 2023 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

1. Үйл ажиллагааны тухай:

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (“Эрдэнэ Ресурс” “Корпораци” эсвэл “Компани” гэх) нь Канад Улсад төвтэй, үнэт болон суурь металлын хайгуулын үйл ажиллагааг Монгол Улсад эрхэлдэг. Компанийн голлох төсөл нь Монгол улсын Баянхонгор аймагт орших Баянхөндий алтны төсөл юм. Компанийн үнэт цаас нь Торонтогийн Хөрөнгийн Бирж дээр “ERD”, Монголын Хөрөнгийн Бирж дээр “ERDN” тикертэйгээр арилжаалагддаг. Компанийн албан хаяг нь 1300-1969 Upper Water Street, Halifax, Nova Scotia, B3J 2V1.

Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь Монгол Улс дах хайгуул хөгжүүлэлт бөгөөд Баянхөндий алтны төсөл дээр төвлөрч ажиллаж байна.

2. Тайлангийн үндэслэл

а) Мөрдсөн стандарт

Нэгтгэсэн санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу бэлтгэсэн болно. Тодруулга 4-т дурдсанаас гадна бүх санхүүгийн жилүүдэд тогтвортойгоор мөрдөгдсөн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг тодруулга 3-д толилуулсан.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг ТУЗ-ийн 2024 оны 3 сарын 27-ны өдрийн шийдвэрээр гаргасан.

б) Хэмжилтийн суурь

Тодруулга 3-т зааснаас бусдаар нэгтгэсэн санхүүгийн тайлан нь өмнө жилүүдийн зардалд үндэслэн бэлтгэсэн.

в) Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцооллууд

Санхүүгийн тайланг бэлтгэх явцад СТОУС-ын шаардлагаар Компанийн удирдлага нь тайлан болон холбогдох тодруулгуудтай холбоотойгоор материаллаг өөрчлөлт, нөлөө үзүүлэх тооцоолол, таамаглалууд дэвшүүлэхийг шаарддаг. Үнэлэмж, тооцооллууд нь олон хүчин зүйлд үндэслэх бөгөөд түүхэн туршлага, одоогийн болон хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн нөхцөл байдал гэх мэт мэдээллүүдийг ашигласан. Бодит үр дүн нь эдгээр тооцооллоос зөрөх магадлалтай. Удирдлагын тооцоолол болон таамаглал, үндэслэл, төсөөлөл болон эдгээр нь нягтлан бодох бүртгэлийн стандарт, тодруулгуудад хэрхэн нөлөөлөх талаар доор танилцуулав.

- i) *Нөлөөллийг тодорхойлох:* Компани нь удирдан чиглүүлэх эрхийн хүрээнд өөрийн хөрөнгө оруулалт дахь хяналт, эсвэл хяналтаа хадгалаагүй тохиолдолд түүний ашиг сонирхол чухал нөлөөллийн тодорхойлолтод нийцэж байгаа эсэхийг үнэлэх ба өмчийн аргаар бүртгэнэ. Удирдлага нь хууль ёсны эзэмшлийн ашиг сонирхол ба аж ахуйн нэгжүүдийн шийдвэр гаргах үйл явцын оролцоонд дүгнэлт хийх замаар дээрхийг тодорхойлдог. 2023 оны 1 сарын 10-нд Монгол дахь охин компани болох Эрдэнэ Монгол ХХК-ийн хяналтад өөрчлөлт орсноор удирдлага нь Эрдэнэ Монголд нөлөөлөх нөлөөллийг тодорхойлж, өмчийн аргаар хараат компани болгож бүртгэсэн.
- ii) *Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралт:* Компани НББОУС 28 дагуу Хараат аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт ба хамтарсан үйлдвэрлэл дэх хувь оролцоотой холбоотой үнэ цэнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрөхөд хүргэж болзошгүй үнэ цэнийн бууралтын үзүүлэлт байгаа эсэхийг тодорхойлдог. Энэхүү дүгнэлт нь бодит үнэ цэнийн бууралт ихээхэн хэмжээний эсвэл удаан үргэлжилсэн эсэхийг үнэлэхэд чухал ач холбогдолтой үнэлгээг шаарддаг бөгөөд энэ нь албан ёсны үнэ цэнийн бууралтын шинжилгээг шаарддаг. Дээрх үнэлгээг гаргахдаа Компанийн удирдлага хөрөнгө оруулалтын бодит үнэ цэн нь дансны үнээс бага байх хугацаа, цар хүрээ, хөрөнгө оруулалтын тогтвортой байдал, хөрөнгө оруулагчийн санхүүгийн эрүүл мэнд, бизнесийн төлөв байдал, үүнд: санхүүжилт авагчийн хайгуулын төслийн одоогийн болон ирээдүйн хүлээлт, санхүүжилтийн мөнгөн урсгалын өөрчлөлт зэрэг багтдаг бөгөөд дүүнээс гадна бусад олон хүчин зүйлсийг үнэлдэг.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Санхүүгийн тайлангийн тодруулга
(Канад доллараар)

2022 болон 2023 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

- iii) *Төлбөрийн хэрэгсэл, валют:* Санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгасан Компани болон охин компани тус бүр нь үйл ажиллагаа явуулахад анхдагч зах зээлийн валютыг ашигладаг. Толгой компани канад доллар, Монгол дахь охин компаниуд монгол төгрөгөөр үйл ажиллагаа эрхэлдэг.
- iv) *Хайгуул, үнэлгээний хөрөнгийн үнэ цэнийн тооцоолол:* Хайгуул, үнэлгээний хөрөнгүүдийг тайлант хугацаа бүрт үнэ цэнээ алдсан эсэхийг шалгадаг. Компани нь хайгуул хийх эрх байгаа эсэх, хайгуулын зөвшөөрөл сунгагдсан эсэх, үргэлжлүүлэн хийгдэх хайгуулын ажлын зардал төсөвлөгдсөн эсэх зэргийг харгалзан холбогдох үнэлэмжийг гаргаж үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг байгаа эсэхийг тодорхойлно.
Хэрэв үнэ цэнийн бууралтын үзүүлэлт эсвэл хайгуул, үнэлгээний хөрөнгийг нөхөгдөх үнийн албан ёсны тооцоолол хийсэн бол түүнийг техникийн хувьд боломжтой, арилжааны хувьд ашигтай гэж үзсэн тохиолдолд үндсэн хөрөнгөд дахин ангилна. Нөхөгдөх дүнг хөрөнгийн борлуулалтын цэвэр үнэ ба ашиглалтын үнэ цэнийн аль ихээр бүртгэнэ.
- v) *Хувьцаанд суурилсан урамшуулал:* Ажилтнуудад олгосон хувьцаанд суурилсан урамшууллыг олгосон өдрийн бодит үнэ цэнээр бүртгэнэ. Бодит үнэ цэнийг BlackScholes үнэлгээний загварыг ашиглан тооцох ба ингэхдээ бодит үнэ цэнийг бүртгэх үед мэдэгдэж буй мэдээлэлд тулгуурлан хүлээгдэж буй хэлбэлзэл болон хүлээгдэж буй хугацаа гэх мэт хувьсагчуудын хүрээнд шийдвэр гаргаж үнэлэхийг шаарддаг.
- vi) *Нөхөн сэргээлтийн тухай:* Удирдлагын зүгээс жилийн хугацаанд бий болсон баримт, нөхцөлд үндэслэн талбайн нөхөн сэргээлтийн тухай шийдвэр гаргах шаардлагагүй гэж үзсэн.

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Дараах нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь хэрэв өөрөөр дурдаагүй бол эдгээр бодлогууд нь тайлагнасан бүх хугацаанд тууштай хэрэглэгдэнэ:

а) Нэгтгэсэн тайлан бэлтгэсэн суурь

Санхүүгийн нэгтгэсэн тайланд Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци ба түүний охин компани Анианресорсиз ХХК (2022, 2023 оны 12 сарын 31-ээр дуусгавар болсон нэг жилийн хугацаанд) болон Эрдэнэ Монгол ХХК (2023 оны 1 сарын 10 хүртэл) орсон. 2023 оны 1 сарын 10-ны өдөр Баянхөндий алтны төслийг хөгжүүлэх зорилтын хүрээнд Монголиан Майнинг Корпорэйшн-тэй стратегийн түншлэлийн гэрээ байгуулж, Эрдэнэ Монгол ХХК-ийн хяналтыг хуваах болсонтой холбоотойгоор Эрдэнэ Монгол ХХК-ийг нэгтгэсэн тайланд бүртгэхгүй (Тодруулга 5).

Хөрөнгө оруулагч нь хөрөнгө оруулалтын хувьсах өгөөж ба хөрөнгө оруулалтдад эзэмших эрх мэдлээрээ дамжуулан өгөөжид нөлөөлөх чадвараар дамжуулан хяналтыг хэрэгжүүлдэг. Компани хяналтыг авсан өдрөөр охин компанийг нэгтгэсэн санхүүгийн тайланд бүртгэх бөгөөд энэхүү хяналтыг алдсанаар нэгтгэлээс хасна. Компани хоорондын бүх гүйлгээ, үлдэгдэл, биелэгдээгүй ашиг, алдагдлыг нэгтгэх явцад хасна. Охин компанийн эзэмшилд өөрчлөлт гарснаар:

- i) Охин компанитай холбоотой хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлүүдийг нэгтгэлийн тайлангаас хасах;
- ii) Охин компанийн эзэмшилд өөрчлөлт орсоноор Компанитай холбоотой үлдсэн хөрөнгө оруулалтыг бодит үнийн дүнгээр хүлээн зөвшөөрөх бөгөөд СТОУС-ын стандартын дагуу бүртгэнэ.
- iii) Охин компанийн эзэмшилд өөрчлөлт орохоос өмнөх ашиг, алдагдлыг бүртгэнэ.

Санхүүгийн нэгдсэн тайланг гаргахдаа компани хоорондын үлдэгдэл болон гүйлгээг хасаж бүртгэсэн. Үнэ цэнийн бууралтын дүгнэлт байхгүй тохиолдолд бодит бус ашгийг бодит бус алдагдлын адил хасаж тооцно.

б) Гадаад валют

Компанийн үйл ажиллагааны бүртгэлийн валют нь Компани болон охин компани тус бүрийн үйл ажиллагаа явуулж буй улсын үндэсний мөнгөн тэмдэгтийг ашигладаг. Хуулийн этгээд тус бүрийн

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

2022 болон 2023 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

санхүүгийн тайланг бэлтгэж байхад хуулийн этгээдийн ашигладгаас өөр валютаар (гадаад валют) хийсэн гүйлгээг тухайн өдрийн ханш давамгайлж буй валютаар тооцно. Тайлангийн төгсгөл бүрт гадны валютаар хийгдсэн бүртгэлүүд нь тухайн өдрийн валютын ханшаар дахин хөрвүүлэгдсэнээр нэгдсэн алдагдлын дэлгэрэнгүй тайланд валютын зөрүүний олз эсхүл гарз хэмээн бүртгэх үндэслэл болно.

Валютын ханшийн өндөр зөрүүтэйгээс бусад үед орлого зардлын зүйлсийг тухайн хугацааны дундаж валютын ханшаар тооцно. Валютын ханш өндөр зөрүүтэй үед гүйлгээ хийгдсэн өдрийн ханшаар тооцно. Үнэт цаасны гүйлгээ хийх тохиолдолд гүйлгээ хийсэн тухайн өдрийн ханшаар тооцно. Гадаад валютаар тооцогдсон хөрөнгө, өр төлбөрийн хувьд валютын зөрүү гарсан тохиолдолд бусад хуримтлагдсан хөрвүүлгийн залруулгын орлого (алдагдал)-д тооцогдоно.

Гадны үйл ажиллагааны хяналтын алдагдлын хувьд бүх ханшийн зөрүүг Компанийн эзэмшигчидтэй холбоотой үйл ажиллагааны өмчөөр хуримтлуулсан ба орлогын тайланд борлуулалтын ашиг эсвэл алдагдал байдлаар бичсэн.

с) Санхүүгийн хэрэглүүр

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээс бусдаар санхүүгийн хөрөнгө, өр төлбөр нь гүйлгээний зардал, анхны хүлээн зөвшөөрөлтийг нэмсэн бодит үнэ цэнээр тооцогдоно. Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр тодорхойлогдсон санхүүгийн хөрөнгө нь гүйлгээний зардал, анхны хүлээн зөвшөөрөлтийг зарлагдсан бодит үнэ цэнээр тооцогдоно.

Үнэ цэнийг ангилахдаа тухайн нийт үнэ цэнийг бүрдүүлж буй доод зардалд тулгуурладаг. Дараах мэдээлэлд Компанийн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг ангилж, хэмжих нэгжээр илэрхийлэв:

Төрөл	Ангилал	Хэмжих нэгж
Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах	Санхүүгийн хөрөнгө	Элэгдэл тооцсон зардал
Авлага	Санхүүгийн хөрөнгө	Элэгдэл тооцсон зардал
Худалдаа болон бусад өглөг	Санхүүгийн өр төлбөр	Элэгдэл тооцсон зардал

Компани нь санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээний гэрээний эрх дуусгавар болох эсвэл санхүүгийн хөрөнгө, түүнийг өмчлөхтэй холбоотой бүхий л эрсдэл, өгөөжийг бусад хуулийн этгээдэд шилжүүлэх үед тайлангаас хасна. Бүртгэл хийгдэхгүй болсноос үүссэн ашиг, өр төлбөрийг алдагдлын нэгдсэн тайланд тусгана.

Компани нь өр төлбөрийг өр төлбөрийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх, цуцлах, хугацаа дуусах үед тайлангаас хасна. Хассан өр төлбөрийн дансны дүн ба төлсөн, төлөх өр төлбөрийн (бэлэн бус хөрөнгө шилжүүлсэн, өр төлбөрийг төлсөн) зөрүүг цэвэр (алдагдал) орлогын нэгдсэн тайланд бүртгэнэ.

д) Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт

Хараат компани гэдэгт шийдвэрт нь чухал нөлөө үзүүлдэг боловч хяналтын эрхгүй компанийг хэлнэ. Компанийн хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын санхүүгийн үр дүнг өмчийн аргын дагуу бүртгэнэ. Өмчийн аргын дагуу хөрөнгө оруулалтыг анх бодит үнэ цэнээр нь бүртгэж, худалдан авсан өдрөөс хойш холбоотой компанийн ашиг, алдагдлаас Компанийн хувь эзэмшлийн эзлэх хувийг тооцон бүртгэхийн тулд дансны үнийг нэмэгдүүлж, бууруулна. Компанийн хувь эзэмшлийн эзлэх хувийн ашиг эсвэл алдагдлыг (орлого) алдагдлын тайланд бүртгэсэн бөгөөд хараат компанийн бусад дэлгэрэнгүй (орлого) алдагдлыг бусад дэлгэрэнгүй (орлого) алдагдалд тусгасан.

Компани болон хараат компанийн хооронд хийгдсэн гүйлгээний биелэгдээгүй ашгийг Компанийн хараат компани дахь хувь эзэмшлийн эзлэх хувьд тооцон хасна. Шилжүүлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралт нотлогдсон гүйлгээнээс бусад бодит бус алдагдлыг мөн хасна. Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын хувь хэмжээнд орох өөрчлөлтөөс үүсэх ашиг, алдагдлыг (орлого) алдагдлын тайланд бүртгэнэ.

Компани нь хараат компаниудад оруулсан хөрөнгө оруулалтын үнэ цэн буурсныг нотлох бодитой нотолгоо байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст үнэлдэг. Хэрэв үнэ цэн буурсан бол хараат компанийн

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

2022 болон 2023 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

үндсэн хөрөнгийн Компанийн хувь эзэмшлийн хувьцааны дансны үнийг түүний нөхөгдөх дүнтэй харьцуулснаар (борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэн болон ашиглалтын үнэ цэнийн аль их байгааг) тооцох ба (орлого) алдагдлын тайланд бүртгэнэ.

e) Хайгуул, үнэлгээний хөрөнгө

Хайгуулын өмнөх зардлыг зардлаар хүлээн зөвшөөрдөг. Эрдсийн нөөц тогтоохтой холбоотой бүх шууд зардлыг хайгуулын төсөл тус бүрээр катипалжуулна. Хайгуулын төсөл эсвэл талбайн боломжийг тодорхойлж, ТУЗ-өөр батлагдаж хайгуул, үнэлгээний зардал капиталжих хүртэлх хугацаанд гарсан хайгуулын зардлыг үйл ажиллагааны зардлаар зарлагдана.

Хайгуул, үнэлгээний хөрөнгийг эхлээд зардал байдлаар хэмжин, биет хөрөнгөөр ангилдаг. Хайгуул, үнэлгээний хөрөнгөнд: хайгуул, судалгаа хийх, хайгуулын өрөмдлөг, суваг малталт, дээж авах эрхийг олж авах болон төслийн хайгуул, үнэлгээтэй холбоотой бусад шууд зардлууд орно.

Хайгуул, үнэлгээний үнэ цэнийн бууралтыг нягтлахдаа хөрөнгийн дансны дүн нь нөхөн төлөгдөх дүнгээс давж байвал тус бүрээр нь эсвэл мөнгө бий болгох нэгжийн түвшинд дахин нягтална. Үүнийг бий болоход, тодорхойлсон санхүүгийн жилд дансны дүнгийн эсрэг бүрэн барина.

Хайгуул, үнэлгээний хөрөнгийг тогтмол дахин үнэлдэг ба эдгээр зардлыг хамгийн багадаа дараах нөхцөлүүдийн аль нэгийг хангасан үед шилжүүлнэ:

- i) Эдгээр зардлууд нь хайгуул болон хөгжүүлэлт хийх боломжтой газрыг буцааж авах эсвэл худалдан авах; эсвэл
- ii) Хайгуул, үнэлгээний үйл ажиллагаа хийх боломжтой газар нь үнэлгээний эсвэл бусад эдийн засгийн нөхөн төлөгдөх баталгаагүй, нөөцийн шатандаа хараахан хүрээгүй мөн идэвхтэй, чухал үйл ажиллагаа тухайн талбайд үргэлжлээгүй эсвэл ирээдүйд төлөвлөгдөөгүй.

Эрдсийн нөөцийг олборлох техникийн үндэслэл, эдийн засгийн үр өгөөж нь тодорхойлогдсон тохиолдолд хайгуул, үнэлгээний хөрөнгийг дээрх байдлаар ангилахгүй. Хайгуул болон үнэлгээний хөрөнгийг дахин ангилахаас өмнө үнэ цэнийн бууралт, эсвэл үнэ цэнийн бууралтын алдагдлын хүлээн зөвшөөрөх шаардлагатай.

f) Үндсэн хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмж

Үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтын алдагдлын зардлаар хэмждэг. Зардалд хөрөнгө авахтай шууд холбоотой өртгүүд багтана. Өөрөө барьж байгуулсан хөрөнгийн өртөгт: материалын өртөг, хөдөлмөрийн зардал болон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах нөхцөлийг бий болгоход шууд хамаарах бусад зардал багтдаг.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцоолохдоо тэдгээрийн зардал, үлдэх үнэ цэнийн цэвэр дүн, ашиглалтын тооцоолсон хугацааг хуваарилах бууралтын балансын аргаар тооцно:

Хөрөнгө	Суурь	Хэмжээ
Тээвэр, хээрийн хэрэгсэл	Буурах үлдэгдэл	30%
Тоног төхөөрөмж, тавилга, эд ашиг	Буурах үлдэгдэл	20%
Програм хангамж, компьютер	Буурах үлдэгдэл	33%

Үндсэн хөрөнгө ашиглагдах хугацаанаас эхлэн элэгдэл тооцогдоно. Шаардлагатай тохиолдолд элэгдлийн аргууд, ашиглалтын хугацаа, үлдэх үнэ цэнийн дүнг санхүүгийн жилийн төгсгөл тутамд хянаж тохируулна.

g) Хувьцаанд суурилсан урамшуулал

Ажилтнуудын урамшуулал болгон олгосон хувьцаанд суурилсан урамшууллыг олгосон өдрийн бодит үнэ цэнээр Блэк Шолсийн үнэлгээний загварыг ашиглан тооцно. Хувьцаанд суурилсан урамшуулал бодит үнэ

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Санхүүгийн тайлангийн тодруулга
(Канад доллараар)

2022 болон 2023 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

цэнийг бүртгэх үед мэдэгдэж буй мэдээлэлд тулгуурлан хүлээгдэж буй хэлбэлзэл болон хүлээгдэж буй хугацаа гэх мэт хувьсагчуудын хүрээнд тооцогддог.

Ажилтнуудын урамшууллаас бусад хувьцаанд суурилсан урамшууллын гүйлгээ болон ижил төстэй урамшуулал, үйлчилгээ үзүүлж буйг зах зээлийн үнийг найдвартай тооцоолж чадахгүйгээс бусад тохиолдолд хүлээн авсан бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн бодит үнээр хэмждэг.

h) Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)

Компани нь энгийн хувьцаанд ногдох суурь болон хорогдуулсан нэгж хувьцааны ашиг болон алдагдлыг тайлагнадаг. Нэгж хувьцааны суурь алдагдлыг тооцоолохдоо энгийн хувьцаа эзэмшигчидтэй холбоотой ашиг болон алдагдлыг тухайн хугацаанд зах зээлд буй нийт хувьцааны жигнэсэн дундаж тоонд харьцуулан тооцно. Нэгж хувьцааны хорогдуулсан алдагдлыг энгийн хувьцаа эзэмшигчдийн тохируулсан ашиг болон алдагдлыг хорогдуулах боломжтой нийт энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоонд харьцуулан, тохируулж тооцно.

Компани нь опцион, варрант болон бусад хэрэгслүүдийн хорогдуулах үр нөлөөг тооцохдоо төрийн сангийн хувьцааны аргыг ашигладаг. Энэхүү аргаар: нэгж хувьцааны хорогдуулсан алдагдлыг тооцоолоход ашигласан хувьцааны жигнэсэн дундаж тоо нь хувьцааны опцион хэрэгжүүлсэн, хувьцаа худалдан авах варрант, түүнтэй адилтгах хөрөнгийг ашигласнаас олсон орлогыг Компанийн энгийн хувьцааг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр буцаан худалдан авахад ашиглана хэмээн тооцоолсон.

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөгдсөн стандартууд

2023 оны 1 сарын 1-ээс нягтлан бодох бүртгэлийн доорх стандартуудыг мөрдөж эхэлсэн. Эдгээр өөрчлөлтүүдийг шилжилтийн холбогдох заалтуудын дагуу хийсэн.

НББОУС 1 – Нягтлан бодох бүртгэлийн ил тод байдал

2021 оны 2-р сард НББОУС нь НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга, СТОУС мэдэгдэл 2 Материаллаг байдлын дүгнэлт, НББОУС 8 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооны өөрчлөлт ба алдаанд нэмэлт өөрчлөлт оруулсан. Компани нь тус өөрчлөлтийн 2023 оны 1 сарын 1-с мөрдөж эхэлсэн. Нэмэлт өөрчлөлтүүд нь нягтлан бодох бүртгэлийн бодлогод ямар нэгэн өөрчлөлт оруулаагүй ч санхүүгийн тайланд тусгагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэлд нөлөөлсөн. Нэмэлт өөрчлөлтүүд нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг "чухал" гэхээсээ илүү "материал"-ыг тодруулахыг шаарддаг. Нэмэлт өөрчлөлт нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг ил тод болгоход материаллаг байдлыг ашиглан, хэрэглэгчдэд санхүүгийн тайлангийн бусад мэдээллийг ойлгоход тусалж, аж ахуйн нэгжид хамаарах нягтлан бодох бүртгэлийн бодлогод хэрэгцээтэй мэдээллээр хангахад юм. Удирдлага нэмэлт өөрчлөлттэй уялдуулан шаардлагатай тохиолдлуудад Тодруулга 3-т заасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээллүүдийг шинэчилсэн.

Доорх стандартыг нягтлан бодох бүртгэлд мөрдөгдөж эхлээгүй.

НББОУС 1 – Санхүүгийн тайлангийн танилцуулга

2020 оны 1 сарын 23-нд НББОУС нь НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулгад өөрчлөлт оруулан, өр төлбөрийн ангиллыг илүү ерөнхий болгосон. Нэмэлт өөрчлөлтөөр өр төлбөрийг эргэлтийн болон эргэлтийн бус гэж ангилах нь өр төлбөрийг барагдуулах эрхийг хэрэгжүүлэх хүлээлтээс ялгаатай нь тайлант хугацааны эцэст үүссэн эрхээс хамаарна гэж тодотгосон. Энэхүү нэмэлт өөрчлөлтөөр төлбөр тооцоо нь харилцагч тал руу бэлэн мөнгө, өмчийн хэрэгсэл, бусад хөрөнгө болон үйлчилгээг шилжүүлэхийг хэлнэ гэж тодотгосон. Нэмэлт өөрчлөлтийн хэрэглээ нь хэтийн төлөвт тулгуурлан хийгдэх бөгөөд Компанид нөлөө үзүүлээгүй.

Энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2024 оны 1 сарын 1-ний өдрөөс хойш хүчин төгөлдөр мөрдөх бөгөөд энэхүү хугацаанаас өмнө даган мөрдөхийг зөвшөөрсөн. Компани нь нэмэлт өөрчлөлттэй холбоотой санхүүгийн үр нөлөөг үнэлсэн бөгөөд энэхүү стандартыг мөрдөж эхэлснээр Компанид материаллаг өөрчлөлт орохгүй.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Санхүүгийн тайлангийн тодруулга
(Канад доллараар)

2022 болон 2023 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

5. Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт

2023 оны 1 сарын 10-нд Компани нь Баянхөндий алтны төслийг хөгжүүлэх зорилгоор Монголиан Майнинг Корпорэйшн (“ММС”) тэй стратегийн түншлэл болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсныг мэдээлсэн. Стратегийн түншлэлийн үндсэн нөхцөлүүдийг доор дурдав:

- ММС нь гурван үе шаттайгаар 40 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж, Хөндий, Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрөл, Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг Эрдэнэ Ресурсийн Монгол дахь охин компани болох Эрдэнэ Монгол ХХК (“ЭМ”) -ын 50%-тай тэнцэх хувьцааг хөрвөх нөхцөлтэй өрийн бичиг хөрвөх үед эзэмшинэ.
- Эрдэнэ Ресурс нь ЭМ-ын 50%-г эзэмшихээс гадна Хөндий, Алтан Нар, Улаан тусгай зөвшөөрлийн хүрээнд эхний 400,000 унц алтны олборлолтоос давсан олборлолт болон дээрх тусгай зөвшөөрлүүдийн орчимд 5 км-ийн талбайд эзэмших тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд 5%- ийн борлуулалтын орлогын төлбөр (“Net smelter return” буюу “NSR”) (цаашид “БОТ” гэх) авах нөхцөлтэй.

Жилийн эцэст буюу 2024 оны 1-р сарын 23-нд ЭМ нь хөрвөх нөхцөлтэй өрийн бичгийн хөрвүүлсэнтэй холбогдуулан 50%-ийг төлөөлсөн хувьцааг нэмж гарган, ММС эзэмших болсон.

2023 оны 12-р сарын 31-нд дуусгавар болсон жилийн хугацаанд Эрдэнэ Ресурс нь ЭМ-ын хувьцааны 100 хувийг эзэмшиж байсан ч Стратегийн түншлэлийн гэрээний засаглалын зарим заалтуудын дагуу ЭМ-ын тодорхой үйл ажиллагааг Эрдэнэ Ресурс дангаар удирдах эрхийг хязгаарласан. 2023 оны 1-р сарын 10-ны өдөр ЭМ-ын хяналтыг хуваан, хөрөнгө, өр төлбөрийг бүртгэхийг зогсоосон. Гэсэн хэдий ч Удирдлагын зүгээс Эрдэнэ Ресурс нь ЭМ-ын шийдвэр гаргах үйл явцад томоохон нөлөө үзүүлж байгааг харгалзан энэ өдрөөс эхлэн хөрөнгө оруулалтыг тооцохдоо эздийн өмчийн аргыг ашиглаж эхэлсэн.

Компани нь ММС-ийн хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнийн тооцоолол буюу зах зээлийн оролцогчдын харилцан тохиролцооны үндсэн дээр, ЭМ дахь хөрөнгө оруулалтын эзлэх хувийн бодит үнэ цэнийг 53,527,101 адоллар гэж тооцсон. Үр дүнд нь 2023 оны 12-р сарын 31-ээр дуусгавар болсон жилийн нэгдсэн орлогын нэгдсэн тайланд хяналт алдсанаас үүдсэн 5,110,896 долларын гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүүг хасч 6,544,863 долларын ашиг тусгагдсан.

Дараах хүснэгтүүдэд ЭМ-д оруулсан хөрөнгө оруулалтын санхүүгийн мэдээллийг 2023 оны 1-р сарын 10-ны өдрийн байдлаар (тайлангаас хасахаас өмнөх байдлаар) хураангуйлан харуулав. Доорх дүн нь компани хоорондын хасалтаас өмнөх дүн:

		1 сарын 10 2023
Мөнгө болон түүнтэй адилтгах	\$	254,049
Дансны авлага		69,558
Бусад		43,236
Эргэлтийн хөрөнгө		366,843
Богино хугацаат өр төлбөр		(1,145,712)
Эргэлтийн хөрөнгийн дүн		(778,869)
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	Тодруулга 6	42,130,165
Үндсэн хөрөнгө	Тодруулга 7	520,046
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	\$	42,650,211
Нийт хөрөнгийн дүн	\$	41,871,342

Дараах хүснэгтүүд нь хөрөнгө бүртгэх нягтлан бодох бүртгэлийн зорилгоор Компанийн хийсэн бодит үнэ цэнийг харгалзан ЭМ-ын нэгтгэсэн санхүүгийн мэдээллийн хураангуй юм. Компанийн хөрөнгө оруулалтын дансны үнэд ЭМ-ын хураангуй санхүүгийн мэдээллийг нийцүүлэх нь дараах байдалтай байна.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Санхүүгийн тайлангийн тодруулга
(Канад доллараар)

2022 болон 2023 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

	12 сарын 31 2023
Нийт эргэлтийн хөрөнгө	\$ 10,692,069
Нийт эргэлтийн бус хөрөнгө	96,529,698
Нийт богино хугацааны өр төлбөр	(55,973,036)
Нийт урт хугацааны өр төлбөр	-
Нийт хөрөнгө	\$ 51,248,731
12 сарын 31-ний байдлаар	2023
Орлого	\$ -
Алдагдал	2,278,370

	12 сарын 31 2023
ЭМ-ийн нийт хөрөнгө	\$ 51,248,731
Эрдэнэ Ресурсийн эзэмшил	100.00%
Эрдэнэ Ресурсийн ЭМ-ийн эзэмшдэг хөрөнгө	51,248,731
ЭМ-д оруулсан хөрөнгө оруулалтын дүн	51,248,731

6. Хайгуул, үнэлгээний хөрөнгө

	Баянхөндий	Алтан Нар	Улаан	Зуун мод ба бусад	Нийт
2023.01.01 үлдэгдэл	\$ 36,183,734	\$ 4,257,954	\$ 1,688,477	\$ 923,991	\$ 43,054,156
Нэгтгэлийн хасалт (Тодруулга 5)	(36,183,734)	(4,257,954)	(1,688,477)	-	(42,130,165)
Нэмэгдэл	-	-	-	1,043,280	1,043,280
Валютын ханшийн шилжилтийн нөлөө	-	-	-	(5,765)	(5,765)
2023.12.31 үлдэгдэл	\$ -	\$ -	\$ -	\$ 1,961,506	\$ 1,961,506
2022.01.01 үлдэгдэл	\$ 30,910,999	\$ 4,246,301	\$ 1,797,500	\$ 973,653	\$ 37,928,453
Нэмэгдэл	7,628,060	288,818	1,726	53,351	7,971,955
Валютын ханшийн шилжилтийн нөлөө	(2,355,325)	(277,165)	(110,749)	(103,013)	(2,846,252)
2022.12.31 үлдэгдэл	\$ 36,183,734	\$ 4,257,954	\$ 1,688,477	\$ 923,991	\$ 43,054,156

Монгол Улс дахь ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл нь гурван жилийн хугацаанд хүчинтэй байх ба хугацааг 12 хүртэл жилээр сунгах боломжтой. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаатай олгодог бөгөөд 20 хүртэл жилээр 2 удаа сунгах боломжтой. Тусгай зөвшөөрлүүдийн жилийн төлбөрийг төлснөөр тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр байна. 2023 оны 1-р сарын 10-аас эхлэн Баянхөндий, Алтан нар, Улаан тусгай зөвшөөрөлд хийсэн хайгуул, үнэлгээний ажлуудыг тухайн өдрөөс эхлэн хараат компанид хийсэн хөрөнгө оруулалт хэсэгт тайлагнана.

Баянхөндий алтны төсөл

Баянхөндий алтны төсөл нь Монгол Улсын Баянхонгор аймагт, 2309 га Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд оршдог ба 2019 оны 8 сард Монгол Улсын Ашигт Малтмал, Газрын Тосны Газар ("АМГТГ") нь ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгосон. Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрөл нь 2023 оны 9 сарын 25-нд танилцуулсан "Bayan Khundii Gold Project Feasibility Study NI 43- 101 Technical Report" нэртэй тайлан дахь Баянхөндийн геологийн ба үйлдвэрлэлийн нөөцийг багтаасан.

Алтан нар алтны төсөл

Алтан Нар алтны төсөл нь Монгол Улсын Баянхонгор аймагт, Эрдэнэ Ресурсийн Баян Хөндий алтны төслөөс хойд зүгт 16 км-т оршдог. Эрдэнэ Ресурс нь алт, мөнгө, хар тугалга, цайрын нөөц бүхий Алтан

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

2022 болон 2023 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

Нар төслийг агуулсан 4669 га талбайг хамрах Цэнхэр Номин хайгуулын тусгай зөвшөөрлийг Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрөл болгон, 2020 оны 3 сарын 5-нд Ашигт Малтмал Газрын Тосны Газар бүртгэсэн.

Улаан

Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай нь Баянхөндийгөөс баруун зүгт хил залгаа, нийт 1780 га талбайг хамардаг. Хайгуулын тусгай зөвшөөрөл нь 12 жилийн 9 дэх жилдээ хүчин төгөлдөр байна.

Зуун Мод зэс молибденийн төсөл ба бусад

Зуун Мод төсөл нь Монгол Улсын Баянхонгор аймагт 6041 га талбайг хамардаг бөгөөд тусгай зөвшөөрлийн талбайд молибден-зэсийн нөөц бүхий орд оршдог. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2011 онд олгосон. 2021 оны эцэст Компани түүхий эдийн үнийн өсөлттэй холбогдуулан энэхүү төслийн стратеги болон эдийн засгийн үнэлгээг хийсэн нь төслийн үр ашгийг баталгаажуулсан. 2023 оны дундуур хайгуулын хөтөлбөрөөр порфирийн томоохон ордын эрдэсжилтийг өргөжүүлж, төслийн эдийн засгийн өгөөжийг үргэлжлүүлэн нэмэгдүүлэх боломжтой болов.

7. Үндсэн хөрөнгө

	Тээврийн ба хээрийн тоног төхөөрөмж	Тоног төхөөрөмж, тавилга	Програм хангамж, компьютер	Нийт
Зардал				
2023.01.01 үлдэгдэл	\$ 115,961	\$ 468,387	\$ 222,271	\$ 806,619
Нэгтгэлээс хассан (Тодруулга 5)	(115,961)	(407,073)	(141,302)	(664,336)
Нэмэгдэл	-	-	3,085	3,085
Валютийн ханшийн шилжилтийн нөлөө	-	(11)	(15)	(26)
2023.12.31 үлдэгдэл	\$ -	\$ 61,303	\$ 84,039	\$ 145,342
Элэгдэл ба хорогдол				
2023.01.01 үлдэгдэл	\$ (42,192)	\$ (122,854)	\$ (95,869)	\$ (260,915)
Нэгтгэлээс хассан (Тодруулга 5)	42,192	64,883	37,215	144,290
Элэгдэл	-	(653)	(6,935)	(7,588)
Валютийн ханшийн шилжилтийн нөлөө	-	11	15	26
2023.12.31 үлдэгдэл	\$ -	\$ (58,613)	\$ (65,574)	\$ (124,187)
Дансны дүн				
2023.12.31-нд	\$ -	\$ 2,690	\$ 18,465	\$ 21,155

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Санхүүгийн тайлангийн тодруулга
(Канад доллараар)

2022 болон 2023 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

	Тээврийн ба хээрийн тоног төхөөрөмж	Тоног төхөөрөмж, тавилга	Програм хангамж, компьютер	Нийт
Зардал				
2022.01.01 үлдэгдэл	\$ 130,843	\$ 326,322	\$ 125,890	\$ 583,055
Нэмэгдэл	-	185,638	111,109	296,747
Борлуулалт	-	(1,768)	(5,788)	(7,556)
Валютин ханшийн шилжилтийн нөлөө	(14,882)	(41,805)	(8,940)	(65,627)
2022.12.31 үлдэгдэл	\$ 115,961	\$ 468,387	\$ 222,271	\$ 806,619
Элэгдэл ба хорогдол				
2022.01.01 үлдэгдэл	\$ (34,523)	\$ (98,484)	\$ (76,669)	\$ (209,676)
Элэгдэл	(12,234)	(32,222)	(28,484)	(72,940)
Борлуулалт	-	1,615	5,201	6,816
Валютин ханшийн шилжилтийн нөлөө	4,565	6,237	4,083	14,885
2022.12.31 үлдэгдэл	\$ (42,192)	\$ (122,854)	\$ (95,869)	\$ (260,915)
Дансны дүн				
2022.12.31 үлдэгдэл	\$ 73,769	\$ 345,533	\$ 126,402	\$ 545,704

7. Гэрээгээр хүлээсэн үүрэг

Компани нь Эрдэнэ Монголын эзэмшиж буй Алтан нар, Хөндий, Улаан тусгай зөвшөөрлийн хүрээнд 1%-ийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөр ("NSR")-ийг Сэндстормд төлөх үүрэг хүлээсэн. Сэндсторм нь дээрх тусгай зөвшөөрлийн хувьд ирээдүйн роялти ба стрийм санхүүжилттэй холбоотой давуу эрх эдлэх нөхцөлтэй.

Зуун Мод ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд 1.5%-ийн NSR төлбөр төлөх үүрэгтэй. Энэхүү гэрээний хүрээнд Компани нь Зуун Мод ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд олборлолтын тодорхой шатанд хүрснээр тодорхой хувийг эргэн худалдан авах эрх үүснэ.

9. Орлогын татвар

Компанийн орлогын албан татварын сан нь тооцоолсон дүнгээс ялгаатай байгаа нь Канадын улсын болон мужийн татварын хувийг нэгтгэсэн дүнг орлогын албан татварын өмнөх орлого (алдагдал)-д ашигласан бөгөөд доор харуулав:

	12 сарын 31 2023	12 сарын 31 2022
Албан татварын хувь хэмжээ	29.0%	29.0%
Албан татварын хувь хэмжээгээр тооцсон орлогын татвар (нөхөгдөх)	\$ 151,000	\$ (1,736,000)
Түр хугацааны тооцогдоогүй зөрүүгийн ашиг	6,541,000	700,000
Татварын зорилгоор хасагдах боломжгүй зардлууд	458,000	365,000
Гадаад улсын татварын хувь хэмжээний нөлөө	14,000	609,000
Хараат компанийн хөрөнгө оруулалтын тооцогдоогүй алдагдал	661,000	
Охин компанийн хяналт хуваагдсанаас үүссэн зөрүү	(7,825,000)	
Бусад	0	62,000

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Санхүүгийн тайлангийн тодруулга
(Канад доллараар)

2022 болон 2023 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

Татварын хувь хэмжээг татварын тооцоололдоо ашиглахад: Канад Улсад 29.0% (2022 онд 29.0% байсан), Монгол Улсад 10% (2022 онд 10% байсан).

Дараах хүснэгтэд Компанийн хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгө (өр төлбөр)-ийг тусгасан болно:

	12 сарын 31 2023	12 сарын 31 2022
Урагшлуулсан хөрөнгийн бус алдагдал	\$ 212,000	\$ 1,014,000
Хойшлуулсан орлогын татварын хөрөнгө	212,000	1,014,000
Хэрэгжээгүй гадаад валют	(212,000)	(1,014,000)
Хойшлуулсан цэвэр орлогын албан татварын хөрөнгө (өр төлбөр)	\$ -	\$ -

Дараах түр хугацааны зөрүү, хөрөнгийн бус алдагдлууд болон хөрөнгийн алдагдлуудыг санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгаагүй болно.

	2023.12.31		
	Канад улс	Монгол улс	Нийт
Хөрөнгийн бус алдагдал	\$ 23,867,000	\$ 86,000	\$ 23,953,000
Үндсэн хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмж	272,000	-	272,000
Хувьцаа гаргасан зардал	707,000	-	707,000
Биет бус хөрөнгө	378,000	-	378,000
Хайгуул, үнэлгээний хөрөнгө	26,176,000	3,994,000	30,170,000
	\$ 51,400,000	\$ 4,080,000	\$ 55,480,000

	2022.12.31		
	Канад улс	Монгол улс	Нийт
Хөрөнгийн бус алдагдал	\$ 21,060,000	\$ 3,014,000	\$ 24,074,000
Үндсэн хөрөнгө, үйлдвэр тоног төхөөрөмж	268,000	-	268,000
Хувьцаа гаргасан зардал	1,227,000	-	1,227,000
Биет бус хөрөнгө	378,000	-	378,000
Хайгуул, үнэлгээний хөрөнгө	5,737,000	9,418,000	15,155,000
	\$ 28,670,000	\$ 12,432,000	\$ 41,102,000

2023 оны 12 сарын 31-ний байдлаар Компани ирээдүйд шилжүүлэн татвар ногдох орлого хорогдуулах хөрөнгийн бус алдагдлууд үүссэн. Энэхүү алдагдлуудаар татвар ногдох орлого хорогдуулах хугацааг доор үзүүлэв:

	12 сарын 31 2023	12 сарын 31 2022
2023	-	349,000
2024	5,000	488,000
2025	6,000	685,000
2026	1,535,000	-
түүнээс цааш	23,138,000	26,047,000
	\$ 24,684,000	\$ 27,569,000

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Санхүүгийн тайлангийн тодруулга
(Канад доллараар)

2022 болон 2023 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

10. Хувьцаат капитал, нэмэлт хөрөнгө

Хувьцаа гаргах бүрэн эрх

Нэрлэсэн үнэгүй, хязгааргүй энгийн хувьцаа гаргах эрхтэй.

Гаргасан хувьцаа

Компани нь 2022 оны 12 сарын 22-нд хаалттай хүрээнд нийт \$7,000,248 долларын санхүүжилт татан төвлөрүүлсэн. Хаалттай санхүүжилтийн хүрээнд Эрдэнэ Ресурс тус бүрийг \$0.27 доллараар үнэлсэн 25,926,844 ширхэг үнэт цаасны нэгжийг гаргасан. Үнэт цаасны нэгж бүр нь Компанийн нэг Энгийн хувьцаа болон Энгийн хувьцаа худалдан авах эрх болох хагас (½) Варрант ("Варрант")-аас бүрдсэн. Варрант бүр нь санхүүжилт хаагдсанаас хойш 2 жилийн хугацаанд нэг Энгийн хувьцааг \$0.40 доллараар худалдан авах эрхийг олгосон. Эрдэнэ Ресурс нь санхүүжилттэй холбоотойгоор \$127,699 доллар болон 97,031 ширхэг зуучлалын варрантыг үнэт цаастай адил нөхцөлтэйгөөр гаргасан. Санхүүжилтийг татан төвлөрүүлэхэд Компани \$53,836 долларын зардал гаргаж, нийтдээ \$6,818,713 долларын цэвэр санхүүжилт татсан.

2022 оны 8 сарын 4-нд Компани нь нийт \$7,180,106 долларын санхүүжилтийг татан төвлөрүүлсэн. Хаалттай санхүүжилтийн хүрээнд Эрдэнэ Ресурс тус бүрийг \$0.30 доллараар үнэлсэн 23,933,687 ширхэг үнэт цаасны нэгжийг гаргасан. Үнэт цаасны нэгж бүр нь Компанийн нэг Энгийн хувьцаа болон Энгийн хувьцаа худалдан авах эрх болох хагас (½) Варрант ("Варрант")-аас бүрдсэн. Варрант бүр нь санхүүжилт хаагдсанаас хойш 2 жилийн хугацаанд нэг Энгийн хувьцааг \$0.45 доллараар худалдан авах эрхийг олгосон. Эрдэнэ Ресурс нь санхүүжилттэй холбоотойгоор \$151,048 доллар болон 236,826 ширхэг зуучлалын варрантыг үнэт цаастай адил нөхцөлтэйгөөр гаргасан. Санхүүжилтийг татан төвлөрүүлэхэд Компани \$64,817 долларын зардал гаргаж, нийтдээ \$6,964,241 долларын цэвэр санхүүжилт татсан.

Варрант

2022 оны 12 сарын 21-нд 13,060,452 ширхэг варрантыг хаалттай санхүүжилтийн хүрээнд гаргасан. Санхүүжилт хаагдсанаас хойш 24 сарын хугацаанд нэгж хувьцааг \$0.40 доллараар хэрэгжүүлэх боломжтой. Варрантын хугацаа 2024 оны 12 сарын 21-нд дуусна.

2022 оны 7 сарын 8, 2022 оны 8 сарын 4-нд 12,203,670 ширхэг варрантыг хаалттай санхүүжилтийн хүрээнд гаргасан. Санхүүжилт хаагдсанаас хойш 24 сарын хугацаанд нэгж хувьцааг \$0.45 доллараар хэрэгжүүлэх боломжтой. Варрантын хугацаа 2024 оны 7 сарын 8, 2024 оны 8 сарын 4-нд дуусна.

2022, 2023 оны 12 сарын 31-ны байдлаар варрант хэрэгжээгүй. Үүнээс гадна 2023 онд хугацаа дууссан варрант байхгүй (2022 - 44,845,052 варрантын хугацаа дууссан).

2022, 2023 оны 12 сарын 31-ний байдлаар варрантын мэдээллийг доор харуулав:

	2023.12.31		2022.12.31	
	Варрантын тоо	Жигнэсэн дундаж хэрэгжих үнэ	Варрантын тоо	Жигнэсэн дундаж хэрэгжих үнэ
1 сарын 1-ний байдлаар	25,264,122	\$ 0.42	44,845,052	\$ 0.60
Гаргасан	-	-	25,264,122	0.42
Хугацаа дууссан	-	-	(44,845,052)	0.60
12 сарын 31-ний байдлаар	25,264,122	\$ 0.42	25,264,122	\$ 0.42
12 сарын 31-ний байдлаар хэрэгжих боломжтой	25,264,122	\$ 0.42	25,264,122	\$ 0.42

2022, 2023 оны 12 сарын 31-ний байдлаар варрантын мэдээллийг доор харуулав:

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Санхүүгийн тайлангийн тодруулга
(Канад доллараар)

2022 болон 2023 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

Хэрэгжүүлэх үнэ	Варрантын тоо	Гэрээний жигнэсэн дундаж хугацаа (үлдсэн жил)
0.42	25,264,122	0.76
	25,264,122	0.76

Гаргасан варрант бүрийн үнэ цэнийг варрант гаргах үед Блэк Шолсийн опционы үнэлгээний загварыг ашиглан, жигнэсэн дундаж үнээр тогтоосон:

	2022.12.31
Гаргах өдрийн хувьцааны үнэ	\$ 0.29
Хэрэгжүүлэх үнэ	\$ 0.42
Эрсдэлгүй хүүгийн түвшин	3.5%
Хүлээгдсэн хугацаа	2.0 years
Хүлээгдсэн хэлбэлзэл	46%
Хүлээгдсэн ногдол ашиг	0.0%
Гаргах өдрийн зах зээлийн жигнэсэн дундаж үнэ	\$ 0.04

Хүлээгдсэн хэлбэлзлийг үнэт цаасны түүхэн ханшийн хэлбэлзлийг харгалзан тооцсон.

Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөр болон Залгамж халааны төлөвлөгөө

2023 оны 6 сарын 22-ны өдөр Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар “Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөр” (ХСУБХ буюу Omnibus plan) баталсан. ХСУБХ нь опцион (“Опцион” буюу “Options”), хязгаарлалт бүхий хувьцааны нэгж (“ХБХН” буюу “RSUs”) гүйцэтгэлд суурилсан хувьцааны нэгж (“ГСХН” буюу “PSUs”) ирээдүйд олгогдох хувьцааны эрх (“ИОХЭ” буюу “DSUs”) зэрэг хувьцаанд суурилсан урамшууллыг харьцангуй уян хатан байдлаар компани болон охин компаниудын захирал зөвлөхүүд, ажилтнуудад олгон, урт хугацаанд тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлнэ. ХСУБХ нь батлагдсанаар Залгамж халааны төлөвлөгөө болох хувьцаанд суурилсан опционы төлөвлөгөө, ИОХЭ-ийн төлөвлөгөөг орлоно. Тус төлөвлөгөөнүүдийн дагуу олгогдсон урамшуулал нь хүчин төгөлдөр хугацаа дуусгавар болтол хүчинтэй.

ХСУБХ нь хувьсах төлөвлөгөө бөгөөд тус хөтөлбөрийн дагуу олгосон энгийн хувьцааний тоо хэмжээ нь (Залгамж халааны төлөвлөгөөгөөр олгосон урамшууллыг багтаасан) Компанийн гаргасан болон арилжиж буй энгийн хувьцааны нийт хэмжээний 10%-иас хэтрэхгүй байх ёстой.

ХСУБХ болон залгамж халааны төлөвлөгөөний дагуу олгогдсон урамшууллын дэлгэрэнгүй мэдээллийг дор харуулав:

Хувьцааны опцион

Одоогоор олгогдсон опцион нь Компанийн Залгамж халааны төлөвлөгөөний дагуу олгогдсон. Компани нь Залгамж халааны төлөвлөгөөний дагуу 10%-ийн опционы урамшууллын хөтөлбөр (“Хөтөлбөр”) хэрэгжүүлдэг байсан ба энэхүү хөтөлбөрийн хүрээнд Компанийн ТУЗ-ийн гишүүд, удирдлага, ажилтан албан тушаалтнуудад компанийн хувьцааг худалдан авах боломж бүхий опционыг олгодог. Опционыг хэрэгжүүлэх, олгох нөхцөлүүдийг ТУЗ тодорхойлно. Опционыг олгохдоо нөхцөлийг өөрөөр заагаагүй бол олгосон өдрөөс эхлэн шууд хэрэгжүүлэх боломжтой.

2023 оны 12 сарын 31-ний байдлаар жигнэсэн дундаж хэрэгжүүлэх үнэ \$0.36 бүхий 6,325,000 опционыг олгосон (2022 – \$0.31 жигнэсэн дундаж хэрэгжүүлэх үнэ бүхий 4,355,000 опцион олгосон). 3,145,000

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Санхүүгийн тайлангийн тодруулга
(Канад доллараар)

2022 болон 2023 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

опционы хугацаа дууссан (2022 онд 2,595,000 опционы хугацаа дууссан байна). Мөн жигнэсэн дундаж хэрэгжүүлэх үнэ нь \$0.24 доллар бүхий 250,000 опционыг хэрэгжүүлж \$60,500 орлого олсон (2022 – \$0.29 хэрэгжүүлэх үнэ бүхий 60,000 опцион хэрэгжүүлж, \$17,100 орлого олсон).

2022, 2023 оны 12 сарын 31-ний байдлаар үнэт цаасны опционд гарсан өөрчлөлтүүд:

	2023.12.31		2022.12.31	
	Опционы тоо	Хэрэгжүүлэх боломжтой жигнэсэн дундаж үнэ	Опционы тоо	Хэрэгжүүлэх боломжтой жигнэсэн дундаж үнэ
1 сарын 1-ний байдлаар	17,555,000	\$ 0.36	15,855,000	\$ 0.45
Олгосон	6,325,000	0.36	4,355,000	0.31
Хугацаа дууссан	(3,145,000)	0.40	(2,595,000)	0.87
Хэрэгжүүлсэн	(250,000)	0.24	(60,000)	0.29
12 сарын 31-ний байдлаар	20,485,000	\$ 0.35	17,555,000	\$ 0.36
12 сарын 31-ний байдлаар хэрэгжүүлэх боломжтой	20,485,000	\$ 0.35	17,555,000	\$ 0.36

2022 болон 2023 онд олгосон бүх опцион нь таван жилийн хугацаанд, шууд хэрэгжүүлэх боломжтой опцион юм. Доорх хүснэгтэд 2022, 2023 оны 12 сарын 31-ний байдлаар хэрэгжүүлэх боломжтой бүх гаргасан опционын мэдээллийг харуулав.

Дуусах хугацаа	2023.12.31		2022.12.31	
	Опционы тоо	Хэрэгжүүлэх тоо	Опционы тоо	Хэрэгжүүлэх тоо
2023.02.04	-	-	50,000	0.50
2023.03.13	-	-	100,000	0.40
2023.06.14	-	-	2,780,000	0.40
2023.10.15	-	-	150,000	0.27
2024.06.20	2,060,000	0.20	2,165,000	0.20
2024.11.29	100,000	0.18	100,000	0.18
2024.12.20	50,000	0.18	50,000	0.18
2025.02.11	50,000	0.27	50,000	0.27
2025.05.13	500,000	0.22	500,000	0.22
2025.08.27	3,155,000	0.49	3,160,000	0.49
2025.12.01	200,000	0.38	200,000	0.38
2026.01.29	100,000	0.43	100,000	0.43
2026.06.23	3,180,000	0.37	3,245,000	0.37
2026.08.18	350,000	0.43	450,000	0.43
2026.10.28	100,000	0.43	100,000	0.43
2027.09.27	4,160,000	0.31	4,180,000	0.31
2027.12.30	175,000	0.30	175,000	0.30
2028.05.09	6,305,000	0.36	-	-
	20,485,000	\$ 0.35	17,555,000	\$ 0.36

2022 болон 2023 оны 12 сарын 31-ний хугацаанд гаргасан опцион бүрийн үнэ цэнийг опцион гаргах үед Блэк Шолсийн опционы үнэлгээний загварыг ашиглан, жигнэсэн дундаж үнээр тогтоосон:

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Санхүүгийн тайлангийн тодруулга
(Канад доллараар)

2022 болон 2023 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

	2023.12.31	2022.12.31
Гаргах өдрийн хувьцааны үнэ	\$ 0.36	\$ 0.31
Хэрэгжүүлэх үнэ	\$ 0.36	\$ 0.31
Эрсдэлгүй хүүгийн түвшин	3.2%	3.0%
Хүлээгдсэн хугацаа	4.4 years	3.7 years
Хүлээгдсэн хэлбэлзэл	56%	62%
Хүлээгдсэн ноогдол ашиг	0.0%	0.0%
Гаргах өдрийн зах зээлийн жигнэсэн дундаж үнэ	\$ 0.17	\$ 0.15

Хүлээгдсэн хэлбэлзлийг үнэт цаасны түүхэн ханшийн хэлбэлзлийг харгалзан тооцсон.

2023 онд гаргасан опцион нь хувьцаанд суурилсан урамшуулал ба захиргааны зардалд \$1,078,275 (2022 – \$629,030) долларын зардал хэлбэрээр тусгагдсан.

Ирээдүйд олгогдох хувьцааны эрх ("DSU")

Компани нь ирээдүйд олгогдох хувьцааны эрх ("ИОХЭ")-ийн төлөвлөгөөг 2013 онд батлан мөрдөж эхэлсэн. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд ирээдүйд олгогдох хувьцааны нэгжийн тоо ширхэг хугацааг ТУЗ тодорхойлох бөгөөд дээрх эрхийг нөхөн төлбөр, урамшуулал болгох эсэхийг мөн тодорхойлно. Олгосон өдрөөс ирээдүйд олгогдох хувьцааны эрхийг шууд хэрэгжүүлэх боломжтой. Хугацаа дуусгавар болох, эсвэл хөтөлбөрт хамрагдсан гишүүн нас барсан тохиолдолд Компани тухайн гишүүний хувийг бэлэн мөнгөөр эсвэл үнэт цаасаар зах зээлийн үнэлгээгээр худалдан авах боломжтой. Энэ нь Компанийн сонголтоор хийгдэх бөгөөд Компани бэлэн мөнгөөр худалдан авахгүйгээр шийдвэрлэвэл энэхүү төлөвлөгөө нь үнэт цаасанд суурилсан хөтөлбөрт шилжинэ. 2023 оны 6 сарын 22-нд батлагдсан хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөрийн төлөвлөгөө дэх ИОХЭ-ийн нөхцлүүд нь хуучин хэрэгжиж байсан ИОХЭ-ийн хөтөлбөрийн заалтуудтай нийцэж байна.

2023 оны 12 сарын 31-ний байдлаар Компани нь нэгж тус бүрийг дунджаар \$0.33 долларын бодит үнэ цэн бүхий 1,492,778 ширхэг ирээдүйд олгогдох хувьцааны эрх олгосон (2022 – \$0.32 үнэлсэн 1,183,910 ширхэг ИОХЭ олгосон). Бодит үнэлгээ нь \$488,234 (2022 – \$376,116) бүхий ИОХЭ нь Захиргаа, удирдлагын зардал болон хайгуулын зардалд тусгагдсан. Эрдэнэ Ресурс нь тухайн онд дунджаар \$0.34 доллараар үнэлсэн 337,800 ширхэг ИОХЭ гаргасан (2022 онд хувьцаа гаргаагүй).

	2023.12.31	2022.12.31
Олгогдсон өдрөөс тооцоолсон 5 өдрийн жигнэсэн дундаж үнэ	\$ 0.33	\$ 0.32

2022, 2023 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн байдлаар ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн тухай мэдээлэл:

	2023.12.31	2022.12.31
	Тоо ширхэг	Тоо ширхэг
1 сарын 1-ний байдлаар	7,287,272	6,103,362
Олгосон	1,492,778	1,183,910
Гаргасан	(337,800)	-
12 сарын 31-ний байдлаар	8,442,250	7,287,272

Хувьцаанд суурилсан урамшуулал

2023 оны 12 сарын 31-ний байдлаар Компани нь \$1,566,509 (2022 – \$1,005,146) долларын хувьцаанд суурилсан урамшууллыг нэгтгэсэн алдагдалд зарлагдсан. Энэ нь бодит үнэ цэнийн дүнд тооцон ХСУБХ болон залгамж халааны төлөвлөгөөний дагуу олгосон опцион ба ИХОЭ юм.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Санхүүгийн тайлангийн тодруулга
(Канад доллараар)

2022 болон 2023 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

11. Хайгуул болон үнэлгээний зардал

2022, 2023 оны 12 сарын 31-ний байдлаар хайгуул болон үнэлгээний зардлын мэдээллийг доор хүснэгтэд харуулав:

	12 сарын 31	
	2023	2022
Элэгдэл хорогдол	\$ -	\$ 91,292
Шууд зардал	111,087	2,566,711
Ажилтан, албан тушаалтнуудын урамшуулал	71,694	720,447
Хувьцаанд суурилсан урамшуулал	664,229	420,226
	\$ 847,010	\$ 3,798,676

12. Захиргаа, удирдлагын зардал

2022, 2023 оны 12 сарын 31-ний байдлаар захиргаа, удирдлагын зардлын мэдээллийг дор харуулав:

	12 сарын 31	
	2023	2022
Захиргааны үйлчилгээ	\$ 935,026	\$ 703,051
Элэгдэл, хорогдол	36,958	38,089
ТУЗ-ийн гишүүдийн төлбөр, нөхөн төлбөр	122,244	126,754
Хөрөнгө оруулагчтай харилцах, маркетинг	318,225	124,672
Оффис, бусад	105,686	102,738
Мэрэгжлийн үйлчилгээний төлбөр	504,095	380,691
Зохицуулагч байгууллагын төлбөр, зардлууд	109,322	115,853
Хувьцаанд суурилсан урамшуулал	902,280	584,920
Томилолтын зардал	103,900	42,216
	\$ 3,137,736	\$ 2,218,984

13. Санхүүгийн хэрэглүүр

Зээлийн эрсдэл:

Зээлийн эрсдэл нь санхүүгийн хөрөнгийн хамгийн өндөр эрсдэлийг агуулдаг. Тайлангийн өдрөөр тасалбар болгон зээлийн эрсдэл хамгийн их хүлээж буй хөрөнгийг харуулбал:

	Дансны дүн	
	12 сарын 31 2023	12 сарын 31 2022
Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах	\$ 4,349,599	\$ 7,421,600
Авлага	6,722	76,582
	\$ 4,356,321	\$ 7,498,182

Компани нь өөрийн бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн дийлэнх хэсгийг Канадын санхүүгийн байгууллагуудад байршуулж зээлийн эрсдэлийг удирддаг бөгөөд удирдлагын зүгээс алдагдал хүлээх эрсдэл бага гэж үздэг. 2023 оны 12-р сарын 31-ний байдлаар 33,759 доллар буюу бэлэн мөнгөний 1% нь Канадаас бусад банкуудад хадгалагдаж байсан (2022 - 268,376 доллар буюу 4%).

Төлбөрийн чадварын эрсдэл:

Компанийн хөрвөх чадварын эрсдэл нь өр төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулах үүргээ биелүүлэхэд үүсэж болзошгүй хүндрэлтэй холбоотой эрсдэлийг хэлнэ. Компани нь энэхүү эрсдэлийн удирдлагын

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Санхүүгийн тайлангийн тодруулга
(Канад доллараар)

2022 болон 2023 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

хүрээнд санхүүгийн хэвийн болон хүндрэлтэй аль ч нөхцөлд шаардлагагүй гарз хүлээхгүйн тулд санхүүгийн өр төлбөр төлөгдөх хугацаанд хангалттай хэмжээний нөөцтэй байх бодлого баримталдаг. Компанийн бүх санхүүгийн өр төлбөрийг ирэх арван хоёр сарын дотор барагдуулахаар төлөвлөж байна.

Зах зээлийн эрсдэл:

Зах зээлийн эрсдэл нь үнэт цаасны ханш, таваарын зах зээл, валютын ханш, хүүгийн түвшин зэрэг зах зээлийн хүчин зүйлсээс шалтгаалан өөрчлөгдөх магадлалтай эрсдэлүүдийг хэлнэ.

а) Хүүгийн эрсдэл

Компани нь илүүдэл бэлэн мөнгийг хүүтэй хадгаламжийн дансанд байршуулж байгаа нь хүүгийн эрсдэл үүсгэх магадлалтай.

б) Гадаад валютын эрсдэл

Компанийн үйл ажиллагааны голлох валют нь канад доллар бөгөөд охин компаниудын голлох валют нь монгол төгрөг юм. Түүнээс гадна, Компани нь америк доллараар санхүүжилт авч, зардлыг гаргасан. Иймээс канад долларын бусад валюттай харьцах хэлбэлзэл нь санхүүгийн хөрөнгө, өр төлбөр болон үйл ажиллагааны үр дүнд нөлөөлөх боломжтой. Валютын хөрвөх эрсдэл бүхий санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдэд ам.доллараар илэрхийлэгдэх бэлэн мөнгө, өглөг, хуримтлагдсан өр төлбөр, монгол төгрөгөөр илэрхийлэгдсэн бэлэн мөнгө, өглөг болон хуримтлагдсан өр төлбөр багтаж байна. Компани нь Канад Улсын банкнуудад канад болон ам.доллар байршуулдаг.

Компанийн гадаад валют (ам.доллар)-ын эрсдэлд өртөх байдлыг доор харуулав:

	12 сарын 31 2023	12 сарын 31 2022
Мөнгөн ба түүнтэй адилтгах	\$ 1,050,778	\$ 311,141
Худалдаа, бусад өглөг	(5,949)	(215,506)
	\$ 1,044,829	\$ 95,635

Ам.долларын ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь 104,500 долларын цэвэр алдагдал дагуулах магадлалтай (2022.12.31 - \$9,600).

Компанийн гадаад валют (монгол төгрөг)-ын эрсдэлд өртөх байдлыг доор харуулав:

	12 сарын 31 2023	12 сарын 31 2022
Мөнгөн ба түүнтэй адилтгах	\$ 876	\$ 35,194
Худалдаа, бусад авлага	2,138	69,559
Худалдаа, бусад өглөг	(18)	(61,274)
	\$ 2,996	\$ 43,479

Монгол төгрөгийн ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь \$300 долларын цэвэр алдагдал дагуулах магадлалтай (2022.12.31 - \$4,300).

с) Үнийн эрсдэл

Компанийн санхүүгийн хэрэгслүүд нь эрдсийн хайгуул, олборлолтын салбарын таваарын үнийн хэлбэлзлээс бусад байдлаар үнийн шууд эрсдэлд орох магадлал багатай.

Бодит үнэ цэн:

Компанийн санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэн нь дансны үнэтэй ойролцоо гэж үздэг. Бодит үнэ цэн нь тооцох өдөр зах зээлд оролцогчдын хооронд хийсэн хэлцлийн дагуу хөрөнгийг худалдахад хүлээн

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Санхүүгийн тайлангийн тодруулга
(Канад доллараар)

2022 болон 2023 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

авах эсвэл өр төлбөрийг шилжүүлэхэд төлөх үнэ юм. Бодит үнэ цэний түвшин нь бодит үнэ цэнийг ангилан хэмжихэд ашигласан үнэлгээнд тогтоодог:

- Түвшин 1: Хөрөнгө болон өр төлбөрийн зах зээл дэх үнэ;
- Түвшин 2: Түвшин 1-д тогтсон зах зээлийн үнээс бусад шууд болон шууд бусаар тогтоогдох үнэ;
- Түвшин 3: Зах зээлийн үнээс үл хамаарсан байдлаар тогтоогдох үнэ.

14. Холбогдох талууд

Компанийн голлох удирдах ажилтнуудад ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх албан тушаалтнууд багтдаг. Эдгээр голлох удирдлагын ажилтнуудын цалин урамшууллыг доор харуулав:

	12 сарын 31	
	2023	2022
ТУЗ-ийн гишүүдийн цалин	\$ 168,000	\$ 125,000
Хувьцаанд суурилсан урамшуулал	520,400	292,125
Ажилтнуудын цалин, урамшуулал	1,616,957	1,450,459
Голлох албан тушаалтнуудын хувьцаанд суурилсан	554,382	324,839
	\$ 2,859,739	\$ 2,192,423

15. Өрнөсөн үйл явдлууд

Баянхөндий алтны төслийг хөгжүүлэх зорилгоор 2024 оны 2-р сарын 8-ны өдөр Эрдэнэ Ресурс нь ММС-тэй төслийн санхүүжилтийн гэрээг байгуулав. Эрдэнэ Ресурс болон ММС нар нь Хөндий, Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрөл, Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг Эрдэнэ Монгол ХХК ("ЭМ")-ийг хамтран эзэмшдэг ба тус санхүүжилт нь ММС-ээс хувь эзэмшигчийн зээлийн нөхцөлөөр олгогдох юм. Баянхөндий төслийн бүтээн байгуулалтад хувь эзэмшигчийн зээл хэлбэрээр 50 сая ам.долларын санхүүжилт хийгдэнэ. Тус санхүүжилт нь таван үе шаттайгаар хийгдэх ба нэг удаагийн санхүүжилт 5 сая ам.доллараас багагүй байна. Зээлийн хугацаа нь олгогдсон өдрөөс таван жилийн хугацаатай ба 13.8%-ийн хүүтэй, улирал бүр төлөх төлбөрийн нөхцөлтэй. ЭМ нь хүү төлөлтийн эхний дөрвөн хүүгийн төлбөрийг капиталжуулах боломжтой ба зээлийг хугацаа дуусахад бүрэн төлсөн байх нөхцөлтэй. Үлдсэн 30 сая ам.долларыг зээлийн адил нөхцөлтэйгээр ММС олгох боломжтой.

Хувь эзэмшигчээс олгогдох зээлийн хүрээнд Эрдэнэ Ресурс нь Эрдэнэ Монгол дахь өөрийн эзэмшлийн 50% болон Хөндий, Алтан Нар, Улаан тусгай зөвшөөрлийн хүрээнд эзэмших борлуулалтын орлогын төлбөр ("Net smelter return" буюу "NSR") (цаашид "БОТ" гэх)-ийг барьцаа хөрөнгө болгоно. Зээлийн эргэн төлөгдөх хугацаанд талуудын хооронд байгуулсан Стратегийн түншлэлийн гэрээний дагуу ММС давуу эрхийн саналтай байх бөгөөд Эрдэнэ Ресурсийн Зуун Мод төслийн хувьд тэргүүн ээлжид татгалзах эрх эдэлнэ. Эрдэнэ Ресурс нь ММС-тэй адил нөхцөлөөр зээлийн 50%-ийг хувьцаа эзэмшигчийн зээл хэлбэрээр олгох боломжтой.

Орчуулга: Энэхүү тайлан нь англи хэл дээр бэлтгэгдсэн албан тайлангийн орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх мэдээлэл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.